



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК



ГАДААД ШИЛЖҮҮЛГИЙН  
ГҮЙЛГЭЭ ХИЙХ ЗӨВЛӨМЖ

# ГАДААД ШИЛЖҮҮЛГИЙН ГҮЙЛГЭЭ ХИЙХ, ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛЭЭ БАТАЛГААЖУУЛАХ ТУХАЙ

Банк нэг талаас харилцагчийнхаа гадаад гүйлгээг түргэн шуурхай дамжуулах, үйлчилгээгээ олон улсын жишигт нийцүүлэн харилцагчид хүргэх, нөгөө талд гадаадын банк, санхүүгийн байгууллагатай хамтарч ажиллах, тус банкны оршин буй улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх, банкуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) болон харилцагчаа таньж мэдэх ажиллагааны бодлогыг дагаж мөрдөх үүргийг хүлээсэн байдаг.

Олон улсын банкууд, тэдгээрийн зохицуулагч байгууллагуудын хяналт чанга, тавьж буй шаардлага өндөр байдаг. Банкны үйл ажиллагаа нь банк, харилцагчаас цаашлаад улс орны гадаад харилцаа, эдийн засаг, олон улсын худалдаа, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтад ихээр нөлөөлж байдаг. Иймд бид харилцагч болон хамтын ажиллагаатай банкуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд гадаад гуйвууллагын үйлчилгээндээ тодорхой шаардлагуудыг тавьж ажилладаг болно.

## 1. Банк яагаад харилцагчийн гүйлгээнд хяналт тавьж, гүйлгээтэй холбоотой мэдээллийг шаарддаг вэ?

Манай банкны болон хүлээн авагч банкны харилцагчийн гүйлгээг дамжуулж өгч буй банканд хоёр талын харилцагчийн альных нь ч талаар мэдээлэл байхгүй тул дамжуулагч банкуудийн зүгээс төлбөрийн зориулалтыг тодорхой бичих, төлбөр шилжүүлэгч, хүлээн авагчийн мэдээллийг бүрэн дэлгэрэнгүй байхыг шаарддаг. Мэдээллүүд буруу, дутуу, ойлгомжгүй байх тохиолдолд төлбөрийн утга зориулалтыг тодруулах, шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаар мэдээлэл авах зорилгоор гүйлгээг саатуулах, буцаах цаашлаад тусгаарлах, хураах хүртэл арга хэмжээг авч ажилладаг. Иймд харилцагч Та гүйлгээг шилжүүлэхдээ дараах зүйлсийг анхаарснаар гүйлгээ саатах, буцаагдах зэрэг эрсдэлийг бууруулах боломжтой. Үүнд:

- Банканд данс нээлгэх, үйлчилгээ авахдаа өөрийн нэр, оршин суугаа хаяг, холбоо барих суваг, эрхэлдэг бизнесийн үйл ажиллагаа, хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөвөөр мэдээлэх;
- Төлбөр шилжүүлэх, гүйлгээ хийхдээ тухайн төлбөрийн зориулалт, утгыг дэлгэрэнгүй, тодорхой бичих. Тээвэрлэлтийн төлбөр бол дотор нь тээвэрлэгдэх бүтээгдэхүүний талаар гүйлгээний утга хэсэгт оруулах, барааны төлбөр бол ямар бараа болохыг оруулах бөгөөд товчилсон үгсийг ашиглахгүй байх;
- Төлбөр хүлээн авагч, хамтрагч түншийнхээ талаар тодорхой мэдээлэлтэй байж, төлбөрийн зориулалтыг бизнес, үйл ажиллагааныхаа чиглэлтэй уялдуулж бичих;

- Гуравдагч этгээдийн өмнөөс төлбөр шилжүүлэхгүй байх;
- Интернэт болон цахим банкны үйлчилгээ ашиглаж шилжүүлж байгаа төлбөрийн мэдээлэл, гүйлгээний утгыг дэлгэрэнгүй зөв бичих;
- Дамжуулагч банкууд асуулга ирүүлэхдээ хариуг авах тодорхой хугацааг заасан байдаг бөгөөд тус хугацаанд хариуг хүргүүлээгүй тохиолдолд гүйлгээг буцаах нь тус банкуудын эрх байдаг тул төлбөр, шилжүүлэгтэй холбоотой банкнаас нэмэлт мэдээлэл, тодруулга шаардсан тохиолдолд мэдээллийг тухай бүрд нь бүрэн зөв, шуурхай гаргаж ирүүлэх.

## **2. Луйврын гүйлгээ хийгдэхээс сэргийлэх, гүйлгээний мэдээллийг бөглөхөд анхаарах зүйлс**

Сүүлийн үед гадаадын түншүүдтэйгээ и-мэйлээр харилцаж төлбөрөө шилжүүлэх хандлага ихэссэн. Цахимаар мэдээлэл солилцоход шилжүүлэгч болон төлбөр хүлээн авагч талууд и-мэйл хаягаа хакеруулах, фишинг и-мэйл хүлээн авах, луйварт өртөх эрсдэлтэй байдаг тул харилцагч Та төлбөр шилжүүлэгчийн мэдээллээ дараах байдлаар баталгаажуулж байна уу. Үүнд:

- И-мэйл болон чатаар ирсэн дансны мэдээлэл. Хэрэв хүлээн авагчийн данс, хаяг болон бусад мэдээллүүд өөрчлөгдсөн талаар мэдээлэл хүлээн авсан бол хүлээн авагчтай зайлшгүй утсаар холбогдон баталгаажуулж байх;
- Хүлээн авагч талын байнга төлбөр хүлээн авдаг байсан дансны дугаар ойрын хугацаанд өөрчлөгдсөн эсэх, хэрэв өөрчлөгдсөн бол утсаар ярьж баталгаажуулах;
- Сугалаа болон карго хүлээн авахтай холбоотой урьдчилгаа төлбөр шаардсан нь ихэнхдээ луйвар байдаг тул танихгүй хүнд төлбөр шилжүүлснээр төлбөрийг алдах эрсдэлтэй байдаг тул эрсдэлээс сэргийлж гүйлгээ хийхгүй байхыг анхаарах. Төлбөр нэгэнт хүлээн авагчийн банкны дансанд орсон тохиолдолд буцаан татах боломжгүй байдгийг анхаарч ажиллана уу.

Таныг данс нээх, төлбөр тооцоо гүйцэтгэхэд банкнаас тавьж буй шаардлага, нэмэлтээр асууж буй мэдээлэл, баримтууд нь нь Та болон таны бизнесийн түншийн төлбөр тооцоог бүх төрлийн эрсдэлээс сэргийлж, хамгаалж буй алхам юм.



---

### **ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:**

**Утас:** +976 (11) 328086; +976 1900-1977

**Вэб хаяг:** [www.tdbm.mn](http://www.tdbm.mn)

Худалдаа, хөгжлийн банк - Комплайнсын хэлтэс